



# МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ


# СОЁМБОМ ЭДЭЭ

181 /181/ 2021.11.16

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

## ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХАМТАРСАН ХОРООНЫ ЕСДҮГЭЭР ХУРАЛДААН БОЛЖ БАЙНА



Бүгд Найрамдах Турк Улсын нийслэл Анкара хотноо Монгол, Туркийн Эдийн засаг, худалдааны Засгийн газар хоорондын хамтарсан хорооны есдүгээр хуралдаан энэ сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгуулагдаж байна. Хуралдаанд Монголын талаас ажлын хэсгийг Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр ахалж, ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, ГХЯ-ны ОУГЭЗГ-ын захирал С.Сүхболд болон холбогдох яам, агентлагийн төлөөлөгчид оролцож байгаа юм. Цар тахлын улмаас түр хойшлогдоод байсан эл хуралдаанд хоёр тал ихээхэн ач холбогдол өгч, худалдаа, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт хамтын ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэсэн асуудлуудыг

хэлэлцэж байна.

Туркийн Худалдааны сайд Мехмет Муш Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзаж, Монгол, Туркийн худалдаа, эдийн засгийн харилцааг эрчимжүүлэх, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, бизнесийнхний хоорондын харилцааг дэмжихэд анхаарч ажиллахаар тохирч, талууд хоёр талын хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллахаар боллоо.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Туркийн Батлан хамгаалахын сайд Хулуси Акартай албан ёсны уулзалт хийж, хоёр талын батлан хамгаалах салбарын харилцааны асуудлуудыг дэлгэрэнгүй ярилцаж, цэргийн салбарын санхүүгийн хамтын

ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсад үзүүлэх тусламжийг үргэлжлүүлэхээр тохиролцов. Уулзалтын үеэр Батлан хамгаалахын сайд нар Цэргийн түүх, архив, музей, хэвлэл мэдээллийн чиглэлээр хамтран ажиллах санамж бичгийг үзгэллээ. Мөн БХЯ-ны харьяа Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл болон Туркийн Үндэсний Батлан хамгаалах яамны харьяа "МКЕ" Төрийн өмчит компани хамтарсан үйлдвэр байгуулах гэрээнд гарын үсэг зурах ёслолын ажиллагаа болов.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр тэргүүтэй төлөөлөгчид Бүгд Найрамдах Турк Улсыг үндэслэгч Ататуркийн бунханд цэцэг өргөж, хүндэтгэл үзүүлэв.

Түүхэнд энэ өдөр

1959 он.

АЦХЭЯ-ны сайдын тушаалаар Ардын цэргийн удирдах байгууллага болон харьяа анги, салбар, байгууллагуудын тайван цагийн орон тоог шинэчлэн баталжээ.

2009 он.

Монгол Улсын Засгийн газар Чад, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс дахь НҮӨ-ын Энхийг сахиулах MINURCAT ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс анх удаа батальоны хэмжээний цэргийн хүч хандавлагаар шийдвэрлэж, нийт 533 цэргийн алба хаагч үүргээ амжилттай гүйцэтгэн эх орондоо ирсэн юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
1	-12

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
35	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,852.0	2,854.0
EUR	3,275.0	3,285.0
CNY	446.00	447.00
RUB	40.00	40.60
JPY	25.00	25.15
KRW	2.39	2.40

ЗУРХАЙ

2021.11.16 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 12/

ӨВЛИЙН ТЭРГҮҮН ШАРАГЧИН  
ГАХАЙ САРЫН ГУРВАН ХӨХ  
ШАР ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин эмгэг ирнэ.

Наран ургах, шингэх:

08.00-17.14

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Сансар

Суудал:

Гал

Аргын тооллын 11 сарын 16, Ангараг гараг. Билгийн тооллын 12, Дэлгэрүүлэгч одтой, шар луу өдөр. Өдрийн наран 8 цаг 00 минутад мандан, 17 цаг 14 минутад жаргана. Тухайн өдөр хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адегуус муулах, лус тахих, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой.

Хол газар яваар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

## “ОРЧИН ЦАГИЙН ЗЭВСЭГТ ХҮЧИН 100 ЖИЛ” МАРКИЙН НЭЭЛТ БОЛЛОО



“Орчин цагийн Зэвсэгт хүчин 100 жил” сэдэвт шуудангийн маркийн нээлт, анхны өдрийн дугтуйнд гарын үсэг зурж, тамгалах ёслолд ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, “Монгол шуудан” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Анхбаатар нарын тэргүүтэй ЗХЖШ-ын газар, хэлтсийн дарга, Төрийн цэргийн командлагч нар, “Монгол шуудан” компанийн төлөөлөл

хүрэлцэн ирсэн юм.

Энэхүү маркийг бүтээхэд Монгол цэргийн музейн хамт олон мэргэжлийн зөвлөгөө, зураг материалаар ханган ажилласан бөгөөд зураач Б.Баярхүү, дизайнер Ж.Ганхуяг нар урлан бүтээж, 11 мянган ширхэг хэвлэгдэн өнөөдрөөс худалдаанд гарч байна.

“Орчин цагийн Зэвсэгт хүчин 100 жил” сэдэвт блок маркт цэргийн их Жанжин туг, зэвсэгт хүчний өөрчлөлт, хөгжлийг харуулсан

гурван үеийн дүрэмт хувцастай байлдагч, Ардын хувьсгал ялсан түүхэн үйл явдал, Халх голын байлдаан, Монгол ардын армийн зэвсэглэлд орсон пуужин, сөнөөгч онгоц, тээврийн онгоц, машин, нисдэг тэрэг, танк болон НҮБ-аас зохион байгуулдаг энхийг сахиулах ажиллагааны байлдагчид, хүндэт харуул, Батлан хамгаалах яамны байр, Монгол цэргийн оройн дээд шүтээн Бүх цэргийн Их хар сүлдийг тус тус дүрсэлжээ.

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН  
359,093 +491

ЭДГЭРСЭН  
536,920

НАС БАРСАН  
1,682 +10

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН  
6347 +108

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ  
147

ЭДГЭРСЭН  
6078

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 254,511,319

Эдгэрсэн

Нийт: 231,259,145

Нас барсан

Нийт: 5,121,158

Цахим шууданд

ХУРАНДАА ЦОЛ ОЛГОЛОО



ЗХЖШ-ын даргын тушаалаар БХЯ-ны БХЗГ-ын Зэвсэглэл, техникийн бодлогын шинэчлэлт, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Б.Ууганбаатар, Өмнөговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд хурандаа Д.Эрдэнэбаяр, ҮБХИС-ийн Батлан хамгаалахын удирдлагын академийн цэргийн удирдлагын төвийн ахлах багш, дэд хурандаа С.Чинбат, Зэвсэгт хүчний ХШҮГ-ын Мэргэжлийн хяналтын

хэлтсийн дарга, хэмжил зүй, стандартчилал, чанарын улсын ахлах байцаагч, дэд хурандаа Х.Алтанцоож, Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн шинжилгээ, үнэлгээний ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Ө.Тамир, Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын цэргийн командлалын Захиргааны удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа О.Нацагдорж нарт албан тушаалын зэрэглэлийн хурандаа цол олголоо.

22 САЯ ТӨГРӨГИЙН ӨРТӨГ БҮХИЙ АГААР АРИУТГАХ “VIRUS WASHER” ТӨХӨӨРӨМЖ ГАРДУУЛЛАА



Цар тахлыг сөрөн зогсож буй тэмцэл, үйл ажиллагаанд зориулж “Эс Ар Жи Эм” ХХК-иас 22 сая төгрөгийн өртөг бүхий агаар ариутгах “Virus Washer” төхөөрөмжийг 100 жилийн түүхт ой нь тохиож байгаа Цэргийн төв эмнэлэгт хүлээлгэн өглөө. Энэхүү арга хэмжээнд ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг болон албаны хүмүүс, ЦТЭ-ийн удирдлагууд, эмч, эмнэлгийн ажилтнууд оролцов. Энэхүү агаар цэвэршүүлэгч нь ус болон давсны нэгдлийг электролизжүүлж, “Гипохлорит хүчилт ус”-ыг бий болгосноор коронавирус болон бусад төрлийн вирус, бактери, нян, хөгц, мөөгөнцөр харшил үүсгэгч устгах чадвартай ажээ. Цэргийн төв эмнэлгийн удирдлага, хамт олны хувьд цар тахлын эсрэг тэмцэж буй эл хүнд цаг үед үнэтэй хувь нэмэр оруулж, зайлшгүй шаардлагатай байгаа төхөөрөмж хандивласан нь цагаа олсон тусламж болсныг онцолж, талархлаа илэрхийлсэн юм.

СУРГАЛТЫГ АМЖИЛТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 326 дугаар анги Ангийн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл”, “Чадварлаг боловсон хүчин” сургалтын төвтэй хамтран сургалт зохион байгууллаа. Ингэхдээ офицер, ахлагч, ажилтан албан хаагчдыг 10-12 хүний

бүрэлдэхүүнтэй 3 бүлэгт хуваан “Хувь хүний хөгжил, хувь хүний санхүүгийн боловсрол”, “Хүмүүс хоорондын харилцаа” сэдэвт сургалтуудад хамруулсан юм. Сургалтыг сургагч багш н.Алтанцэцэг, н.Даваажав нар энэ сарын 9-11-ний удирдан явуулав. Ахлах дэслэгч А.АЛТАНХҮЯГ

20 ДАХЬ БҮТЭЭЛЭЭ ӨЛГИЙДӨН АВЛАА



Монгол Улсад цэргийн хөгжмийн боловсрол олгодог болсны 30 жилийн ой энэ онд тохиож байна. Уг ойн арга хэмжээний хүрээнд Цэргийн хөгжмийн коллежийн багш, доктор, дэд профессор Ш.Цогтгэрэлийн “Хөгжмийн төрөл зүйл, хөгжмийн зохиолуудын нэршлийн тайлбар” номын нээлт өчигдөр болж өндөрлөв. Номын зохиогч, доктор, дэд профессор Ш.Цогтгэрэлийн хувьд урлагийн салбарт 30 орчим жил тасралтгүй ажиллах хугацаандаа цэргийн хөгжим судлалын анхны докторын зэргийг хамгаалж, олон төрлийн судалгааны бүтээл, сурах бичиг, цэргийн хөгжим судлалын талаарх номоо туурвижээ. Уг ном нь түүний 20 дахь бүтээл аж.

Эрдэм шинжилгээ, нийгмийн түншлэл хариуцсан дэд захирал, ШУ-ны доктор, хурандаа Б.Өлзийхуяг, БХЭШХ-гийн захирал, доктор, профессор, хурандаа Б.Эрдэнэбат нар болон бусад эрдэмтэн судлаачид хүндэт зочдоор уригдаж шинэ номын талаар сэтгэгдлээ илэрхийлсний сацуу үе үеийн шавь нарын төлөөллөөс халуун баяр хүргэж дурсгалын зүйлсийг гардуулсан юм. Доктор, дэд профессор Ш.Цогтгэрэл “Миний бие энэ салбарт олон жил ажиллахдаа хөгжмийн мэргэжлийн нэр томъёоны тайлбар тун хомс байгааг анзаарч энэ чиглэлийн ном бүтээх зорилгоор 10-аад жилийн өмнөөс судалгаагаа эхэлж байлаа. Харин өнөөдөр тус бүтээлийнхээ нээлтийг хийж байгаадаа туйлын

баяртай байна. Энэ ном хөгжмийн мэргэжлээр суралцаж буй оюутан, сурагчид, хөгжимчин, дуучин, удирдаач, хөгжмийн багш нар болон дуу хөгжмийн урлагийг сонирхон судлагч хүн бүхэнд хөгжим, урлагийн мэргэжлийн нэр томъёог төрөлх монгол хэлээрээ уншиж судлах бүрэн боломжийг олгож байгаагаараа онцлог. Аливаа хөгжмийн зохиолын хэмжээ хэмнэлийг зөв илэрхийлэхээс гадна утга, агуулгын онцлогийг сайн мэдэж байж тухайн зохиолыг төгс эгшиглүүлэх боломж олддог. Тиймээс энэ ном олон оюутан, сурагчдын гарын авлага болж чадна гэдэгт итгэлтэй байна” гээд хүрэлцэн ирсэн зочдод баярласан сэтгэгдлээ илэрхийлж, ажлын амжилт, бүтээлийг хүсэн ерөөлөө.

ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ “СААДЫН ЗУРВАС”-ЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭН БОЛОВ



оролцов. “Саадын зурвас”-ын аварга шалгаруулах тэмцээнд Зэвсэгт хүчний 065 дугаар анги болон түүний харьяа 104, 252, 278, 281 дүгээр байгууламж, тусгай рот болон Дундговь аймаг дахь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын нийт 10 багийн 60 гаруй тамирчин хурд хүч, авхаалж самбаа сорин өрсөлдлөө. Тэмцээний нийлбэр дүнгээр “Гимнастикийн талбай туулах” төрлөөр I байрт Зэвсэгт хүчний 065 дугаар анги, II байрт

Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн харьяа 278 дугаар байгууламжийн хамт олон өөрсдийн дотоод нөөц боломжид тулгуурлан биеийн тамир спортыг бүх нийтийн хүртээл болгох, сурталчлах, цэрэгжлийн спорт сонирхогчдын хүрээг тэлэх, байгууллага хоорондын харилцан ажиллагааг бэхжүүлэх, эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх сургалтын материаллаг орчныг бүрдүүлэх зорилгоор саадын зурвас, гранатын болон гимнастикийн талбай бүхий биеийн тамирын цогцолбор хотхоныг тохижууллаа. Энэ сарын 12-ны өдөр тус хотхоны нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд энэ үеэр “Саадын зурвас”-ын цогцолбор тэмцээнийг явуулав. Энэхүү тэмцээнийг цаашид аймгийн Засаг даргын нэрэмжит болгон жил бүр зохион байгуулахаар төлөвлөсөн юм. Тэмцээний нээлтийн ажиллагаанд аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат, ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд хурандаа Ш.Гансүх, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн



командлалын биеийн тамирын мэргэжилтэн, дэд хурандаа Н.Түмэнбаяр, Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн Захирагчийн орлогч, Захиргаа удирдлагын тасгийн дарга, дэд хурандаа Г.Баатархүү, Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламжийн дарга, дэд хурандаа Д.Ганболд болон Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын удирдлагууд

252 дугаар тусгай рот, III байрт Дундговь аймгийн Онцгой байдлын газар, “Ерөнхий цэргийн саад” төрлөөр I байрт Зэвсэгт хүчний 065 дугаар анги, II байрт 252 дугаар тусгай рот, III байрт 104 дүгээр тусгай рот, “Гранат шидэлт” төрлөөр I байрт Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламж, II байрт Зэвсэгт хүчний 065 дугаар анги, III байрт 252 дугаар рот тус тус шалгарлаа.